



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/545

Чингис хот

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн
сургалтын байгууллагад хяналт-үнэлгээ зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6 "а", Хөдөлмөрийн тухай хуулийн 139 дүгээр зүйлийн 139.1.2, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370 дугаар тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам"-ын 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2021 оны 3/3007 дугаартай "Хяналт-үнэлгээ зохион байгуулах тухай" албан бичгийн дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын байгууллагад хяналт үнэлгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга

Л.Батсайхан

Засаг даргын орлогч

Нарийн бичиг

Ц.Туяасайхан

Мэргэжлийн хяналтын газрын
Хөдөлмөрийн хяналтын
улсын байцаагч

Гишүүд:

Г.Уянга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн
Мэргэжилтэн

Ч.Баярмаа

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
газрын Хөдөлмөрийн харилцаа,
хөдөлмөрийн аюулгүй байдал
хариуцсан мэргэжилтэн

2. Хяналт-үнэлгээг чанартай зохион байгуулж, ажиллахыг ажлын хэсгийн дарга (Л.Батсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231012497